

## ХИЧЭЭЛ 3

УНШИХ ЗҮЙЛС: ҮЙЛС 10; ДАГАЛДАГЧДЫН ҮЙЛС, Х. 132-142.

# Хоёр Хүн ба Хачирхалтай Мэдээ

*Хэн Шаббат хичээлийг долоо хоног бүр заадаг вэ?  
Дагалдагч Петр зөвхөн еврейчүүдэд сургаал заадаг  
байжээ. Харин Бурхан өөр төлөвлөгөөтэй  
байсан юм.*

# Н


эгэн өдөр сайхан сэтгэлт Корнел гэдэг хүн ерөөндөө залбирч суулаа. Хэдийгээр тэр еврей хүн биш байсан ч Бурханд итгэж, үргэлж залбирдаг

байв. Гэнэт түүний өмнө тэнгэр элч гарч иржээ. Корнел маш их айсан

байна. "Чи юу хүсээв?" гэж тэр элч шивнэлээ.

"Бурхан залбирлыг чинь сонссон" гэж нөгөө элч намуухан ярив. "Иоппа хот руу хүн явуулж Симон Петр гэдэг хүнийг олж уулзуул гэж Бурхан хэлж байна. Түүнийг гэртээ уригтун" гэж хэлээд нөгөө элч алга болов. Корнелиус тэр даруй хэлсэн бүхнийг нь хийжээ.

Дараа өдөр нь Корнелын зарц нар Иоппа хотод дөхөж явах үед Петр нэгэн байшингийн дээвэр дээр гараад зогсож



### Цээжлэх Ишлэл:

"Бурхан бол нүүр тал хардаггүй"  
ҮЙЛС 10:34.

### Тол Санаа:

Бурханы хүүхдүүд хүн бүхэнд анд найз байж чадна.

байлаа. Петр нилээд өлсөж байв. Гэхдээ хоол болтол залбирч байя гэж тэрээр боджээ. Гэтэл Петр нэгэн үзэгдэл үзсэн байна. Тэнгэрээс нэгэн том цагаан даавуу мэт зүйл бууж ирэхийг тэрээр харжээ. Дотор нь янз бүрийн амьтад, шувууд харагдана. "Петр, энэ амьтдаас алж ид" гэх нэгэн дуу түүнд сонсогдов.

"Их Эзэн минь, би чадахгүй. Би ийм бузар хоолыг өмнө идэж байгаагүй" хэмээн Петр учирлалаа.

Гэтэл нөгөө дуу ийн хэлжээ. "Бурхан энэ бүхнийг цэвэр ариун бүтээсэн. Тиймээс бүү бузар гэж ярь" Петрт нөгөө амьтад хоёр дахин үзэгдлээ.

Тэрээр бүр гайхаж орхив. Дараа нь Ариун сүнс түүний бодлыг тасалдуулан "Доор чамайг гурван хүн хүлээж байна. Тэдэнтэй хамт яв. Би тэднийг чам руу илгээсэн юм" гэж хэлжээ.

Петр тэр даруй доош бууж очоод Корнелын илгээсэн гурван хүнтэй уулзжээ. "Та нарын хайж яваа хүн би байна" гэж тэрээр хэллээ.

Дараагийн өдөр нь Петр зарим нөхдийнхөө хамт нөгөө хүмүүстэй цуг Корнелын очихоор явав. Замдаа явж байхдаа Петр үзсэн үзэгдлийнхээ талаар бодож явлаа. Эцэст нь учрыг ойлгожээ.

Тэднийг зорьсон газраа иртэл тэнд маш олон хүн хүлээж байсан юм. Петр Корнелд хандан, "Бурхан хүн бүрийг хайрладаг болохоо надад ойлгууллаа. Тийм ч учраас Есүсийн тухай яриулахаар намайг тан руу илгээсэн юм."

Дараа нь Петр тэнд байсан хүн бүхэнд Есүсийн тухай ярьж өгчээ. Тэд ч Есүст итгэсэн байна. Петрийг ярьж байхад Ариун сүнс хүн бүрийн дээр ирэв. Тэд Бурханыг чангаар магтан дуулж эхэлжээ. Корнел, түүний гэрийнхэн болон найз нөхөд нь тун удалгүй усаар батлуулсан байна.

Петр нэгэн маш чухал зүйлийг ойлгож авчээ. Бурхан хүмүүсийг хэл яриа, арьсны өнгө эсвэл хаана амьдардгаас нь огт шалтгаалалгүйгээр бүгдийг нь хайрладаг. Үүнийг Бурхан бидэнд ойлгуулахыг хүсэж байна.



# Дасгал Ажил

## ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ уншаад цээжлэх ишлэлээ давтаарай.

**Бурхан** ..... Дээшээ заах.  
**бол нүүр тал** ..... Эрүү рүүгээ заах.  
**хардаггүй.** ..... Үгүй гэж хуруу,  
 толгойгоо сэгсрэх.  
**Үйлс 10:34** ..... Алгаа нийлүүлээд  
 дэлгэнэ.

## НЯМ

Үйлс 10-р бүлгээс сонгож хүүхдэдээ уншиж өгөөрэй. Асуух: Хэрэв чи дотор нь олон янзын амьтадтай цагаан даавуу харвал чамд ямар сэтгэгдэл төрөх бол? Энэ түүхийн эцэст хэн хамгийн баяр жаргалтай үлдсэн бэ? Яагаад? Бурхан хэнд хайртай вэ? Бид хэнийг хайрлаж чадах вэ?

Залбирахаасаа өмнө "Есүс надад хайртай" дууг хамтдаа дуулаарай.

## ДАВАА

Янз бүрийн үндэстнүүдийн хүмүүсийн нүүр царайны зургийн цуглуулга хийгээрэй. (нэг том цаасан дээр янз бүрийн хуучин сэтгүүлээс зурагнууд хайчилж наана уу) Эсвэл номын зураг хараарай. Зүс царай, хэл яриа өөр ч хүн болгоныг хайрладаг Бурханы хайрын тухай хүүхдэдээ ярьж өгөөрэй.


## МЯТМАР

Өөр үндэстний хоол хийж идэхээр төлөвлөөрэй. (Хятад, Итали, Мексик, Энэтхэг г.м.)



## ЛХАГВА

Шаббат хичээл дээр хийсэн амьтны багаа хэн нэгэнтэй хуваалцаж, Петр болон Корнелын тухай түүхийг ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл цаасан тавгаар амьтны баг хийж өгөөрэй. Жишээ нь: морь, нохой, муур г.м.)



## ПҮРЭВ

15 минут хүүхэдтэйгээ хамт гадуур алхаж яваарай. Алхаж явахдаа Петр хэрхэн Иоппа хотоос Корнелын очих гэж 50 км алхсан тухай ярьж өгөөрэй. Нэг км, 50 км хоёрын ялгааг төсөөлүүлээрэй. (нэг газраас нөгөө газар хүрэх зайг оруулан тайлбарлаж болох юм.) Асуух: Чи тийм хол алхаж чадах уу?

## БААСАН

Гэрийнхэнтэйгээ хамт Библийн түүхийг жүжиглээрэй. Нэгэн цагаан даавуун дээр янз бүрийн чихмэл болон хуванцар амьтдыг тавиарай. Хүүхдээрээ ямар ямар амьтан болохыг нэрлүүлээрэй.

Петр болон Корнел хоёрыг уулзалдуулахдаа нөхөрсөг байдлаар тэврэлдэн уулзуулаарай. Хүн бүрийг хайрладаг байхад нь гэр бүлийнхэнд маань туслаач гэж Бурханд хандан залбираарай.